



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 12 (345)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *"Монголын нууц товчоог"-г мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Их, дээд сургууль, коллежийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Дэд бүтцийн салбарын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2004 оны гуравдугаар сарын 29

№ 12 (345)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

138.	Борислав Борисович Мещаниновыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 21	230
139.	"Монголын нууц товчоо"-г мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай	Дугаар 23	230
140.	Тэгнүүлын албаны "Алдар" медаль бий болгох тухай	Дугаар 24	231

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

141.	Журам батлах тухай	Дугаар 278	233
142.	Их, дээд сургууль, коллежийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 23	235
143.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 26	235
144.	Үндэсний хорооны дүрэм, ажиллах журам батлах тухай	Дугаар 27	236
145.	Бүсийн зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай	Дугаар 28	238
146.	Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих тухай	Дугаар 29	241
147.	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 30	241
148.	Цэргийн мэргэжилтний тухай	Дугаар 31	241
149.	Журам батлах тухай	Дугаар 32	242
150.	"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шагнал олгох тухай	Дугаар 33	244

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

151.	Хөтөлбөр, бүтэц, удирдлагын орон тооны тухай	Дугаар 8	245
------	--	----------	-----

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

152.	Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай	Дугаар 07	252
------	--	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 21

Төрийн ордон, Улаанбаатар хот

Борислав Борисович Мещаниновыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Элчин зөвлөхөөр ажиллаж байсан Борислав Борисович

Мещаниновыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 23

Төрийн ордон, Улаанбаатар хот

"Монголын нууц товчоо"-г мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай

Монголын ард түмэн олон зууныг өртөөлсөн үндэсний соёлын гайхамшигт өв санг бүрдүүлсний дотор ном судрыг эрдмийн дээд эрдэнэ хэмээн сүслэн бүтээж, үнэт эдээр баримтаглан өргөө гэрийнхээ хойморт залж, үр удмаараа гэгээрч боловсрон, дээдлэн хадгалж ирсэн гэгээн уламжлалтай билээ.

"Монголын нууц товчоо" бол Монголын их хаадын угсаа гарвал, монголчуудын ахуй амьдрал, үндэсний түүх, хэл бичиг, утга соёл, ардын аман зохиол, бөө мөргөл, зан заншлын их нэвтэрхий толь, монгол хэлний үгийн урлагийн сонгодог бүтээл, нүүдэлчний соёлын үл давтагдах хосгүй шинж чанараараа ижилгүй товойж, үеийн үед гайхагдсаар эрин зууныг эзэлсэн их туульс, "тал нутгийн анхилам үнэр нэвт шингэсэн түүх, он цагийн дарааллын бичиг мөн".

Монголын бичмэл түүхэн сурвалжийн ууган дээж бичиг, эртний монгол уран зохиолын гайхамшигт дурсгал энэхүү өв тэгш туурвилыг даяар олноороо мөнх эрхэмлэн, үндэсний бахархлын эрх дархтайгаар дээдлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь

заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

1. Шижир алт, цалин цагаан мөнгөөр чимэглэсэн, эрдэнийн чулуун шигтгээт хосгүй нэг хувь "Монголын нууц товчоо" -г урлан бүтээж Төрийн хүндэтгэлийн өргөөний хойморт залсугай.

2. "Монголын нууц товчоо" -г айл өрх бүр өргөө гэрийнхээ хойморт залж, сүслэн дээдэлж байхыг Монголын нийт ард иргэдэд зөвлөсүгэй.

3. "Монголын нууц товчоо" -г цогц хандлагаар эрчимтэй судалж, бүх шатны боловсролын байгууллагын суралцагсдад үе шаттай судлуулахыг нийт эрдэмтэд, судлаачид, багш сурган хүмүүжүүлэгчдэд уриалсугай.

4. Төрийн хүндэтгэлийн өргөөний хойморт залах "Монголын нууц товчоо"-г урлан бүтээхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 24

Төрийн ордон, Улаанбаатар хот

Тагнуулын албаны "Алдар" медаль бий болгох тухай

ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1. Тагнуулын байгууллагад алба хааж, тасралтгүй олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа генерал, офицер, ахлагчийг шагнах Тагнуулын албаны "Алдар" медаль бий болгосугай.

2. Тагнуулын албаны "Алдар" медалийн

тодорхойлолт, шагнах журмыг нэгдүгээр, загварыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Дээр дурдсан медалиар шагнаж байх эрхийг Тагнуулын ерөнхий газрын даргад олгосугай.

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 24 дүгээр зарлигийн нэгдүгээр хавсралт

НЭГ. Тагнуулын албаны "Алдар" медалийн тодорхойлолт

Тагнуулын албаны "Алдар" медаль нь /цаашид медаль гэх/ дөрвөн зүг хандсан гэрлийн цацраг дээр бат бэх, энх амгалангийн бэлэгдэл номин шигтгээтэй Нацагдорж хээг найман зөвхист хандуулан байрлуулж, монгол үндэсний дугуй хэлбэр бүхий бамбайн голд монгол төрийн уламжлалт бэлэгдэл соёмбыг байрлуулна.

Медаль гурван зэрэгтэй байх ба зэргийг заасан улаан өнгийн босоо зураас бүхий зүүлттэй, ар талд нь медалийн зэргийг заасан "Тагнуулын албаны I, II, III" гэсэн бичээстэй байна.

1 дүгээр зэргийн медалийн Нацагдорж хээ нь

алтан шаргал, 2 дугаар зэргийн медалийн хээ нь мөнгө, 3 дугаар зэргийн медалийн хээ нь хүрлийн өнгөтэй байна.

Медалийг зүүлттэй, тухайн өнгийн гархиар холбоно. Зүүлтийн ар талд хувцсанд тогтоох зүүлттэй байна.

Медалийн зүүлтийн дээд тал нь эвэр угалзан хээтэй, доод хэсэг нь гархин хүрээтэй байна.

Медалийн лентийг улаан зураастай ягаан өнгийн торгомсог эдээр хийнэ.

ХОЁР. Тагнуулын албаны "Алдар" медалиар шагнах журам

1. Тагнуулын байгууллагад үр бүтээлтэй ажиллаж байгаа генерал, офицер, ахлагчийг тагнуулын албаны "Алдар" медалиар шагнахдаа алба хаасан дор дурдсан хугацааг харгалзан үзнэ.

1.1 Тагнуулын албаны "Алдар" 1 дүгээр зэргийн медалиар тагнуулын байгууллагад 20-иос доошгүй жил алба хаасан цэргийн албан хаагчийг;

1.2 Тагнуулын албаны "Алдар" 2 дугаар


зэргийн медалиар тагнуулын байгууллагад 15-аас доошгүй жил алба хаасан цэргийн албан хаагчийг ;

1.3 Тагнуулын албаны "Алдар" 3 дугаар зэргийн медалиар тагнуулын байгууллагад 10-аас доошгүй жил алба хаасан цэргийн албан хаагчийг ;


2. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан иргэнийг Тагнуулын албаны "Алдар" медалиар шагнаж болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны
02 дугаар сарын 20-ны өдрийн 24 дүгээр
зарлигийн хоёр дугаар хавсралт


1. Тагнуулын албаны "Алдар" 1 дүгээр зэргийн медаль




2. Тагнуулын албаны "Алдар" 2 дугаар зэргийн медаль



3. Тагнуулын албаны "Алдар" 3 дугаар зэргийн медаль



Тагнуулын албаны "АЛДАР" медалийн хэмжээ
/мм/-ээр



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 278

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад багтаан санхүүжүүлж байсугай.

1. Киноны шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах журмыг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

2. Киноны шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах хөрөнгийн эх үүсвэрийг Боловсрол,

БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД **А.ЦАНЖИД**

КИНОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ УЛСЫН САНД ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг үндэсний кино урлагийн шилдэг бүтээлийг (баримтат, уран сайхны, хүүхэддэйн хальсны болон DVD шилдэг кино / цаашид "бүтээл" гэх/) шалгаруулан улсын санд худалдан авахад мөрдөнө.

1.2. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд киноны шилдэг бүтээлийг шалгаруулан худалдан авах санал боловсруулах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл (цаашид "мэргэжлийн зөвлөл" гэх) ажиллана.

1.3. Мэргэжлийн зөвлөл нь соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын ажилтан, мэргэжлийн кино зохиолч, кино найруулагч, зураглаач, кино зураач, хөгжмийн зохиолч, урлаг судлаачийн төлөөлөл бүхий арван нэгэн гишүүнтэй байна.

1.4. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэжлийн зөвлөлийн даргыг томилж, бүрэлдэхүүнийг батална.

1.5. Худалдан авсан бүтээлийн дүрсний эх негатив, дууны эх негатив, позитив буюу DVD киноны хуулбарыг чанарын магадлаганы хамт кино архивт хадгална.

Хоёр. Киноны шилдэг бүтээлийг шалгаруулан улсын санд худалдан авах

2.1. Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар улсын санд худалдан авах бүтээлийг шалгаруулан, зохиогчийн үнэлгээг үндэслэн уг бүтээлийг худалдан авах үнийг тогтоох асуудлыг хэлэлцэнэ.

Хуралдааныг мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн 70-аас дээш хувь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

2.2. Улсын санд худалдан авах бүтээл нь дөрвөх шаардлагыг хангасан байна:

2.2.1. монголын үндэсний

уламжлал, түүх, соёл, ёс заншлыг урлаг, уран сайхны өндөр түвшинд харуулсан, эсхүл олон улсын кино наадам, үзлэгт оролцож тодорхой байр эзэлсэн;

2.2.2. хальс болон дууны чанарын

шаардлага хангасан, мэргэжлийн өндөр түвшинд бүтээгдсэн;

2.2.3. олон нийтийн хэвлэл,

мэдээллийн хэрэгслээр сурталчилсан;

2.2.4. садар самуун, хүчирхийлэл

болон мансууруулах бодис, алан хядлага зэрэг хуулиар хориглосон сөрөг үзэгдэл сурталчлаагүй.

2.3. Бүтээлийг шалгаруулахдаа уг кино нь улсын санд худалдан авах шилдэг бүтээлд тавигдах шаардлагыг хангасан эсэх талаар тодорхой үндэслэл бүхий санал дүгнэлтийг мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргана.

2.4. Мэргэжлийн зөвлөлөөс гаргасан санал дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бүтээлийг худалдан авах тухай шийдвэр гаргана.

2.5. Мэргэжлийн зөвлөлийн гишүүний бүтээл нь улсын санд худалдан авах бүтээлийн шалгаруулалтад оролцож байгаа бол түүнийг хуралдаанд оролцуулахгүй.

2.6. Бүтээлийг жилд нэг удаа шалгаруулан улсын санд худалдан авна.

2.7. Шалгаруулалтыг тухайн жилийн 12 дугаар сард зохион байгуулна.

2.8. Шалгаруулалтад оролцох бүтээлийг шалгаруулалт болохоос нэг сарын өмнө мэргэжлийн зөвлөлд ирүүлнэ.

2.9. Бүтээлийг улсын санд худалдан авахад шаардагдах хөрөнгийг тухайн жилийн

төсвийн төсөлд тусгуулж, Соёл урлагийн сангаар дамжуулан санхүүжүүлнэ.

2.10. Бүтээлийг улсын санд худалдан авах хөрөнгийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг тухайн бүтээлийг сурталчлах, опшруулах болон зөвлөлийн гишүүдийг урамшуулахад зарцуулна.

2.11. Бүтээлийг улсын санд худалдан авахад зориулсан хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

2.12. Улсын санд худалдан авсан кино бүтээлийн зохиогчийн эрх төрд шилжинэ. Бүтээлийг шалгаруулж улсын санд худалдан авах тухай шийдвэр гарсан өдрөөс хойш нэг сарын дотор соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Зохиогчийн эрхийн тухай хуулийн 11, 13 дугаар зүйлд заасныг баримтлан тухайн кино бүтээлийг өмчлөх эрх бүхий этгээдтэй зохиогчийн эрхийг төрд шилжүүлэх гэрээ байгуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өөрийн үйл ажиллагааны орлогоор зардлаа бүрэн санхүүжүүлдэг төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн ажил, үйлчилгээг бүтээгдэхүүн нийлүүлэх хэлбэрт шилжүүлэн гэрээгээр ажиллуулсугай.

2. Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, нийлүүлэх бүтээгдэхүүний тоо, өртөг зардлыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээнд тусгаж, биелэлтэд нь хяналт

Их, дээд сургууль, коллежийн талаар авах зарим арга хэмжээний тухай

тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД

А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 1991 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор баталсан журмын 11 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмсүгэй.

"4. Засгийн газар эрэл, хайгуулын ажил явуулах хугацааг 5 хүртэл жилээр сунгахдаа дараахь нөхцөл, байдлыг харгалзан үзнэ:

а/гэрээлэгчийн гаргасан хүсэлт;

б/бүтээгдэхүүн хуваах гэрээний биелэлтийн явц;

в/гэрээт талбайд эрэл, хайгуулын ажил үргэлжлүүлэн явуулах шаардлага."

2. "Журам батлах тухай" Засгийн газрын 1991 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор баталсан журмын гурав дугаар хавсралтад дор дурдсан агуулгатай дараахь нэмэлтийг тус тус оруулсугай.

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2.1. "Гэрээлэгч нь жил бүр газрын түрээсийн төлбөр төлнө." гэсэн 1 дэх хэсэгт:

"3". Эрэл, хайгуулын ажлын хугацааг Засгийн газрын шийдвэрээр 5 хүртэл жил сунгасан үе шатанд гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километр ногдох (үүнд олборлолтын талбайг оруулахгүй)

10.00" гэж;

2.2. "Захиргааны үйлчилгээний шимтгэл" гэсэн 11 дахь хэсэгт

"б/Хайгуулын хугацааг Засгийн газрын шийдвэрээр сунгах 100000" гэж.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЙД БӨГӨӨД
ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙДЫНҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАСАНЖАРГАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Үндэсний хорооны дүрэм, ажиллах журам батлах тухай

Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 6.1, 6.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасгай.

1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хорооны дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Үндэсний хороо үйл ажиллагаа явуулахад

Засгийн газрын 2004 оны 27 дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ, АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний хороо (цаашид "Хороо" гэх)-ны үндсэн зорилго нь бүсчилсэн хөгжлийн талаар баримтлах Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны бүх шатны байгууллага, аймаг, нийслэл, бүсийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, бүс нутгийг хөгжүүлэх талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагч байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг дэмжин зохион байгуулахад оршино.

1.2. Хороо нь үйл ажиллагаандаа Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Хорооны үйл ажиллагааны зардлыг Хороо хуралдаанаараа хэлэлцэн батлах бөгөөд эх үүсвэрийг нь жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

1.4. Хороо нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Хорооны удирдлага, зохион байгуулалт

2.1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Хороог байгуулна.

2.2. Хорооны дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.2.1. Хороог төлөөлөх;

2.2.2. Хорооны хуралдааныг төвлөн хэлэлцэх асуудлыг тогтоож, Хорооны хуралдааныг даргалах;

2.2.3. Хорооны хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон шийдвэр гаргах;

2.2.4. Хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх;

2.2.5. Хорооны гишүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавих;

2.2.6. Хорооны ажлын албаны даргыг томилох;

2.2.7. хууль тогтоомжид заасан болон шаардлагатай гэж үзсэн Хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг Засгийн газар



Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх, танилцуулах.

2.3. Хорооны даргын эзгүйд түүний бүрэн эрхийг Хорооны орлогч дарга хэрэгжүүлнэ.

2.4. Хорооны гишүүд нь хариуцсан салбарын хүрээнд дэх бүсчилсэн хөгжлийн асуудлыг зохицуулж, ажлын үр дүнг Хороонд тайлагнана.

2.5. Хороо нь бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудлаар, холбогдох мэргэжлийн хүмүүс, эрдэмтэд, судлаачдыг оролцуулсан ажлын хэсэг, төслийн бэг ажиллуулж, дүгнэлт гаргуулж болно.

Гурав. Хорооны ажиллах журам

3.1. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.2. Хорооны хуралдаанаар дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

3.2.1. бүсчилсэн хөгжлийн талаар баримтлах Засгийн газрын ерөнхий стратегийн төсөл, бүс-нутгийн болон тухайн бүс дэх салбарын хөгжлийн хөтөлбөр, төслүүд;

3.2.2. бүсчилсэн хөгжлийн төсөл, арга хэмжээг улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх санал, үндэслэл;

3.2.3. бүс нутгийн хөгжлийг хөрөнгө оруулалт, татвар, зээлийн бодлогоор дэмжих санал;

3.2.4. бүс нутгийн хөгжлийг дэмжих сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын хэрэгжилтийн явц, байдал;

3.2.5. бүсийн хэлэлцээр байгуулах журмын төсөл боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх санал, үндэслэл;

3.2.6. чөлөөт бүс, аж үйлдвэрийн паркийн хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудалд өгөх санал, дүгнэлт;

3.2.7. нийслэлийн болон бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн төсөл, тэдгээрийн хэрэгжилтийн явц, байдлын талаар санал боловсруулах;

3.2.8. бүсүүдэд олон улсын байгууллага, гадаад орны зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний үр дүн, тэдгээрийг уялдуулан зохицуулах санал дүгнэлт;

3.2.9. бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн иргэдийн саналыг үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал, үндэслэлийг Үндэсний хороо хэлэлцэж, Засгийн газарт оруулна;

3.2.10. бүсчилсэн хөгжлийн улсын нэгдсэн бодлогын хүрээнд яам, газар, аймаг, нийслэл, хот болон бүсийн Зөвлөлүүдийн хоорондын ажлын уялдаа, зохицуулалтыг хангах, санал, дүгнэлт;

3.2.11. бүсийн зөвлөлүүдэд хуулиар тогтоосны дагуу гүйцэтгэх засаглалын байгууллагын зарим эрх хэмжээг шилжүүлэх санал;

3.2.12. бүсийн зөвлөлүүдийн жил, хагас жилийн ажлын тайлан, үр дүнгийн талаархи мэдээлэл, санал, тэдгээрийн үйл ажиллагаанд Хорооны ажлын албанаас өгсөн үнэлэлт, дүгнэлт;

3.2.13. Хорооны ажлын албаны эрх, үүргийг тогтоож, жил, хагас жилд гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцэх;

3.2.14. Хорооноос байгуулсан ажлын хэсэг, төслийн багийн гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэлгээ, санал.

3.3. Хороо нь Хорооны хуралдааны дэгийг баталж, шийдвэрийн биелэлтэд нь тухайн асуудлыг хариуцсан Хорооны гишүүд тус тусын хяналт тавьж ажиллах бөгөөд Хорооны ажил хэргийн гүйцэтгэлийн ерөнхий хяналтыг Хорооны орлогч дарга, Хорооны гишүүн-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нар хэрэгжүүлнэ.

3.4. Хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд хуралдааны явцад тэмдэглэл хөтөлнө.

3.5. Хорооны тогтоолд Хорооны дарга, тухайн асууалд хариуцсан Хорооны гишүүн, хуралдааны тэмдэглэлд Хорооны орлогч дарга, түүний эзгүйд Хорооны ажлын албаны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.6. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн буюу эсхүл эерсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

3.7. Хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай үед Хорооны дарга ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

3.8. Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Хорооны ажлын алба бэлтгэх бөгөөд хүлээн авч хянаж, хуралд оруулах саналаа Хорооны дарга, орлогч дарга нарт танилцуулна.

3.9. Хорооны даргаас зөвшөөрсний дагуу ажлын алба хурлаар хэлэлцэх асуудлын

танилцуулга, холбогдох бусад материалыг хурал эхлэхээс ажлын 3 өдрийн өмнө Хорооны гишүүдэд тараасан байна.

3.10 Хорооны хуралдаанд холбогдох албан тушаалтнаас гадна шаардлагатай бол аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагын төлөөлөгчийг байлцуулж тэдний санал, дүгнэлтийг сонсож болно.

Дөрөв. Хорооны ажлын алба

4.1. Хорооны ажлын албаны үүргийг Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн стратеги, төлөвлөлтийн алба хэрэгжүүлнэ.

4.2. Хорооны ажлын албаны орон тоо, зохион байгуулалтын бүтэц, ажиллах эрх, үүргийг Хороо хуралдаанаараа хэлэлцэж тогтооно.

4.3. Ажлын албаны дарга нь ажлаа Хороонд улирал тутам, Хорооны орлогч даргад тухай бүр тайлагнаж ажиллана.

4.4. Ажлын алба нь Хорооны албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Бүсийн зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай

Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 10.7-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бүсийн зөвлөлийн ажиллах журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Бүсийн зөвлөлийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аймаг, Дархан, Эрдэнэт хотын засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх арга хэмжээний тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоол, "Гадаад

худалдааны үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай" БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 316 дугаар тогтоол, "Худалдааны байгууллагын зохион байгуулалтыг зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 317 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

Засгийн газрын 2004 оны 28 дугаар тогтоолын хавсралт

БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан бүсийн зөвлөлийн (цаашид Зөвлөл гэх) үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Зөвлөлийн дарга, гишүүд нь бүсийн хүрээнд хуулиар өөрт нь олгогдсон бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлнэ.

1.4. Аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн бус байгууллагын зөвлөлийн гишүүн төлөөлөгч нь Зөвлөлөөс өөрийн хүсэлтээрээ гарах эрхтэй. Уг асуудлыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, энэ тухай Зөвлөлийн дарга бүс нутгийн хөгжлийг дэмжих Үндэсний хороо (цаашид "Үндэсний хороо" гэнэ)-нд мэдэгдэнэ.

1.5. Зөвлөлийн гишүүн-аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөллийг Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах, гаргах асуудлыг тухайн шатны хурал өөрөө шийдвэрлэнэ.

1.6. Зөвлөлийн өдөр тутмын ажлыг Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл

2.1. Зөвлөл нь үйл ажиллагаагаа жилээр төлөвлөж, үр дүнг хагас, бүтэн жилээр Үндэсний хороонд тайлагнана.

2.2. Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай үед Зөвлөлийн дарга, эсхүл Засгийн газраас ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

2.3. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлын товыг Зөвлөлийн хурлаас тогтооно. Хурлын

бэлтгэл ажлыг Зөвлөлийн ажлын алба, уг асуудлыг хариуцсан Зөвлөлийн гишүүнтэй хамтран хангана.

2.4. Зөвлөлийн хурлаар дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

2.4.1. тухайн бүсийн хөгжлийн хөтөлбөр, төсөл, тэдгээрийн хэрэгжилтийн явц, байдал;

2.4.2. бүсийн хөгжлийн нийтлэг зорилтыг хэрэгжүүлэхэд аймгуудын оролцоо, уялдааг хангах асуудал;

2.4.3. бүсийн хөгжлийг дэмжих санд хөрөнгө хуримтлуулах, түүнийг зарцуулах талаар Зөвлөлөөс гаргах шийдвэр;

2.4.4. бүсийн хэлэлцээрээр зохицуулах асуудал, тэдгээрийн хэрэгжилтийн талаархи үнэлэлт, дүгнэлт;

2.4.5. бүсийн хөгжлийн асуудлыг зохицуулах талаар Засгийн газар, Үндэсний хороонд оруулах санал, мэдээлэл;

2.4.6. аймаг, нийслэлийн дотоод бүсчлэл, сум дундын бүсүүдийн хөгжлийг дэмжин зохицуулах асуудал;

2.4.7. бүсийн хөгжлийн тулгуур төв хотуудын ерөнхий төлөвлөгөөний төсөл, тэдгээрийг хэрэгжүүлэхэд аймаг, салбар хоорондын уялдааг хангах асуудал;

2.4.8. бусад бүсийн Зөвлөлтэй хамтран ажиллах асуудал;

2.4.9. хөрш орнуудын хил зэргэлдээ бүс нутгуудтай харилцах асуудал;

2.4.10. бүс нутгийн хөгжлийн асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлт;

2.4.11. Зөвлөлөөс байгуулсан ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн ажлын тайлан, мэдээлэл;

2.4.12. бусад.

2.5. Зөвлөлийн хурлыг гишүүдийн олонхи оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Цөөнх болсон Зөвлөлийн гишүүн үндэслэлээ тайлбарлаж дахин санал хураалгаж болно.

2.6. Зөвлөл нь бүсчилсэн хөгжлийн тодорхой асуудлаар холбогдох салбарын эрдэмтэд, мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулж судалгаа, дүгнэлт гаргуулж болно.

2.7. Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь судалгаа хийх, санал, төсөл боловсруулах, зөвлөлгөө өгөх, Зөвлөлд дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллана.

2.8. Зөвлөл нь шийдвэр гаргахдаа аль нэг талын болон орон нутгийн явцуу ашиг сонирхлын үүднээс хандахгүй байх зарчмыг баримтална.

2.9. Зөвлөлийн гишүүд нь хурлаас гарсан шийдвэрийнхээ төлөө хамтын хариуцлага хүлээх бөгөөд ажлын үр дүнгээ Зөвлөлд тухай бүр тайлагнаж ажиллана.

2.10. Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын тухай танилцуулга, холбогдох материалыг бүрдүүлж, хурал болохоос 7 хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.

2.11. Шаардлагатай гэж үзвэл, Зөвлөлийн хуралд холбогдох хүмүүсийг байлцуулан, тэдний санал, дүгнэлтийг сонсож болно.

2.12. Зөвлөлийн хурлын явцад тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

Гурав. Бусад зүйл

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хууль

тогтоомжид өөрөөр заагаагүй бол зохих журмын дагуу хувийн өмчийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаас санхүүгийн дэмжлэг авч болно.

3.2. Зөвлөл нь бүсийн хөгжлийг дэмжих санд хөрөнгө хуримтлуулах, зарцуулах, хамтарсан гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах үйл ажиллагаанд хуулиар олгосон өөрийн эрх хэмжээгээр оролцоно.

3.3. Зөвлөл нь Засгийн газрын байгууллагатай бүсийн хөгжлийн асуудлаар хамтран ажиллана.

3.4. Зөвлөл нь хуулиар эрх олгосны дагуу бүсийн хөгжлийн нийтлэг зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон санхүүжилтийг бус дотроо зохицуулах эрх эдэлнэ.

3.5. Зөвлөл нь бүрэлдэхүүндээ, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөл байгаагаас шалтгаалахгүйгээр, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлыг гагцхүү тухайн шатны хуралтай тохиролцсоны үндсэн дээр хууль тогтоомжид заасан журмын дагуу хэлэлцэж, шийдвэрлэж болно.

3.6. Зөвлөл нь тухайн бүсэд багтах аймаг, хотын алслагдсан байдал, тулгуур төвүүдийн байршил, тэдгээрийн зах зээлийн багтаамж, гадаадын хөрөнгө оруулалтыг тухайн бүсэд татах зэргээс хамааруулан бүсчилсэн хөгжлийн дотоод уялдаа зохицуулалтыг хангахад Зөвлөлд тус дөхөм үзүүлэх чиг үүрэг бүхий Зөвлөлийн орлогч даргыг томилон ажиллуулж болох бөгөөд энэ тухайгаа Үндэсний хороотой урьдчилан зөвшилцсөн байвал зохино.

3.7. Зөвлөл нь хуралд бэлтгэх, хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, Зөвлөлийн захидал харилцааг шуурхай явуулах зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргатай адилсах ажилтныг Зөвлөлийн ажлын албанд томилон ажиллуулж болно. Уг ажилтныг ажиллуулахтай холбогдсон зардлын асуудлыг тухайн бүсэд багтах аймгуудын Засаг дарга нар харилцан тохиролцсоны үндсэн дээр Тамгын газрынхаа батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

үндсэн дээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дээрх ажил, үйлчилгээнд татан оролцуулах арга хэмжээг зохих хууль тогтосмжийн хүрээнд зохион байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

Хот суурин газрын төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй захын хорооллын хэрэглэгчид болон хөдөөгийн хүн амд зориулан өөрийн хөрөнгөөр цахилгаан эрчим хүч, усан хангамж, мэдээлэл холбооны шугам сүлжээ, нийтийн ахуйн үйлчилгээний зориулалттай цэг барьж тэдгээрийг үндсэн сүлжээ эзэмшигчдэд түрээсээр ашиглуулах буюу тодорхой хугацааны дараа хөрөнгө оруулалтаа нөхөн авах, эсхүл шугам сүлжээ, барилга байгууламжаа ашиглан үйлчилгээ үзүүлж шимтгэл авах нөхцөлтэйгээр гэрээний

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

 ДЭД БҮТЦИЙН
САЙД

Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 28 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд "Монголын үндэсний радио, телевизэд" гэснийг "Монголын үндэсний радио, телевизийн хэрэг эрхлэх газарт" гэж өөрчилсүгэй.

2. "Журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 28 дугаар тогтоолоор батлагдсан "Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хувь этгээдээс хураан төвлөрүүлэх журам"-ын 1-д "дүрмийн" гэснийг "журмын" гэж, 7-д "70 хувийг Монголын үндэсний телевизэд, 10 хувийг "Улаанбаатар" телевизэд, 10 хувийг "MN-25 дугаар суваг" телевизэд, 10 хувийг "Ийгл" телевизэд"

гэснийг "75 хувийг Монголын үндэсний телевизэд, 7 хувийг "Улаанбаатар" телевизэд, 6 хувийг "MN-25 дугаар суваг" телевизэд, 6 хувийг "TV-5" телевизэд, 6 хувийг "TV-9" телевизэд" гэж, 10-т "Монголын үндэсний радио, телевизэд" гэснийг "Монголын үндэсний радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дэргэд" гэж тус тус өөрчлөн мөн журмын 4-ийн "Телевизийн" гэсний өмнө "Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дэргэд" гэж, 8-ын "дамжуулан" гэсний өмнө "шууд буюу давтан" гэж тус тус нэмсүгэй.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

 ДЭД БҮТЦИЙН
САЙД

Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Цэргийн мэргэжилтний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт орон тооны цэргийн

мэргэжилтэнг Монгол Улсаас гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын орон тоонд багтаан ажиллуулж шаардагдах зардлыг нь цаашид

төсөвт тусгаж байхыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунд даалгасугай.

хүрээний төсвийн багцаас санхүүжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Ж.Гуррагчаад даалгасугай.

2. НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт ажиллуулах цэргийн мэргэжилтний 2004 оны цалин, хангамжийг Дипломат албаны тухай хуульд заасан нөхцөл, баталгаатай уялдуулан эрхлэх асуудлынхаа

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД Ж.ГҮРРАГЧАА

ГАДААД ХЭРГИЙН
САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийн 4.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Монгол Улсын цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулахаар хил нэвтрүүлэхэд уг асуудлаар холбогдох хууль тогтоомжид зохицуулалт хийх хүртэл энэ тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан журмыг мөрдсүгэй.

1. "Энхийг сахиулах хүчний хээрийн сургуульд оролцох гадаад орны томилгоот бүрэлдэхүүний агсамж, нормт хангалтын зүйлс, тээврийн хэрэгсэлд хил, гаалийн хялбарчилсан шалгалт хийх, навигацгийн болон бусад үйлчилгээний журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД Ж.ГҮРРАГЧАА

Засгийн газрын 2004 оны 32 дугаар тогтоолын хавсралт

ЭНХИЙГ САХИУЛАХ ХҮЧНИЙ ХЭЭРИЙН СУРГУУЛЬД ОРОЛЦОХ ГАДААД ОРНЫ ТОМИЛГООТ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АГСАМЖ, НОРМТ ХАНГАЛТЫН ЗҮЙЛС, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ХИЛ, ГААЛИЙН ХЯЛБАРЧИЛСАН ШАЛГАЛТ ХИЙХ, НАВИГАЦИЙН БОЛОН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1. Монгол Улсад зохион байгуулагдах энхийг сахиулах хүчний хээрийн сургуульд оролцох гадаад орны томилгоот бүрэлдэхүүнийг хил нэвтрүүлэх, тэдний агсамж, нормт хангалтын зүйлс, зэвсэглэл, техник, тээврийн хэрэгсэлд хил, гаалийн хялбарчилсан шалгалт хийх, навигацын болон бусад үйлчилгээ үзүүлэхэд энэ журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Хил, гаалийн хялбарчилсан шалгалт

3. Бие бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд тэдгээрийн паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичиг, эсхүл цэргийн үнэмлэхийг үндэс болгоно.

2. Монгол Улсад зохион байгуулагдах энхийг сахиулах хүчний хээрийн сургуульд гадаад орны томилгоот бүрэлдэхүүн (цаашид "бие бүрэлдэхүүн" гэх)-ийг оролцуулахад Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль болон

4. Хил, гаалийн хялбарчилсан шалгалтад оруулахад Зэвсэгт хүчний жанжин штаб дор дурдсан материалыг хариуцан бүрдүүлж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн бие бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхээр төлөвлөсөн хугацаанаас 14 хоногийн



өмнө хил хамгаалах болон гаалийн төв байгууллагад хүргүүлнэ:

а/ бие бүрэлдэхүүний нэрсийн жагсаалт;

б/агсамж, хангалтын зүйлс, зэвсэглэл, техник, тээврийн хэрэгсэл, бусад ачааны жагсаалт, марк, тоо хэмжээ;

в/нэвтрэх хилийн болон гаалийн боомт, аяллын маршрут.

5. Хилийн болон гаалийн хялбарчилсан шалгалт хийх байцаагчийг хил хамгаалах болон гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага томилон бэлтгэлийг хангуулна.

6. Шаардлагатай гэж үзвэл хилийн болон гаалийн шалгалтыг холбогдох журмын дагуу, ажлын бус цагаар хяналтын бус талбайд хийж болно.

7. Хялбарчилсан шалгалтын үед хил, гаалиар нэвтрүүлэх бие бүрэлдэхүүн, тэдний агсамж, нормт хангалтын зүйлс, зэвсэглэл, техник, тээврийн хэрэгслийг ирүүлсэн жагсаалт, бичиг баримттай тулган шалгаж, холбогдох бичиг баримтад тэмдэглэл хийнэ.

8. Зэвсэглэл, техник, тээврийн хэрэгслийг улсын болон гаалийн хилээр буцаан нэвтрүүлэхэд өөрчлөлт орсон бол тухай бүр мэдээллийг Зэвсэгт хүчний жанжин штаб хил, гаалийн төв байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй.

Гурав. Навигацын үйлчилгээ

9. Бие бүрэлдэхүүн, тэдгээрийн агсамж, нормт хангалтын зүйлс, зэвсэглэл, техник, тээврийн хэрэгслийг тээвэрлэх агаарын хөлөг нь зохих журмын дагуу урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын агаарын зөйд нислэг үйлдэнэ.

10. Энэ журмын 9 дүгээр заалтад заасан үүрэг гүйцэтгэх агаарын хөлгийн талаар эзэмшигч, эсхүл түрээслэгч талаас урьдчилан ирүүлсэн мэдэгдлийн дагуу бэлтгэл ажлыг Зэвсэгт хүчний жанжин штаб дор дурдсанаар хангана:

а/агаарын хөлгийг хүлээн авах бэлтгэл ажлыг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг холбогдох байгууллагаар авахуулах;

б/агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран авах;

в/агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнийг Улсын нисэхийн тухай хуулийн 11.2-т зааснаар зохицуулах;

г/энэ журмын 9 дүгээр заалтад заасан үүргийг гүйцэтгэх агаарын хөлөг иргэний нисэхийн агаарын зам, нисэх буудлыг ашиглах шаардлагатай бол энэ тухай Иргэний нисэхийн ерөнхий газарт 30 хоногийн өмнө албан ёсоор мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд нислэгийн захиалгыг 5 хоногийн өмнө өгсөн байх.

11. Нислэгийн захиалгыг Монгол Улсын ээронавигацийн мэдээллийн эмхтгэл /AIP/-д заасны дагуу үйлдэнэ.

12. Энэ журмын 9 дүгээр заалтад заасан үүргийг гүйцэтгэх агаарын хөлгийн аюулгүй байдал, зогсоол дээрх харуул, хамгаалалтыг Монгол Улсын мэргэжлийн зохих байгууллагууд хариуцна.

13. Эзэмшигч, эсхүл түрээслэгчийн захиалгаар тухайн агаарын хөлөгт үйлчилгээ хийсэн /шатахуунаар цэнэглэсэн, бусад үйлчилгээ хийсэн гэх мэт/ тохиолдолд түүнтэй холбоотой зардлыг эзэмшигч, эсхүл түрээслэгч хариуцна.

Дөрөв. Бусад тээврийн хэрэгслийн үйлчилгээ

14. Бие бүрэлдэхүүн, тэдний агсамж, нормт хангалтын зүйлс, зэвсэглэл, техник, тээврийн хэрэгслийг төмөр замын тээвэрээр хил нэвтрүүлэх, хөдөлгөөнд оролцуулах тохиолдолд энэ тухай захиалгыг Зэвсэгт хүчний жанжин штаб 30 хоногийн өмнө Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газарт өгнө.

15. Захиалгад төмөр замын тээврийн хэрэгслийн харьяалал, төрөл, тоо, аяллын хугацаа, хүрэх, дамжин өнгөрөх өртөө, байрлах хугацаа, бие бүрэлдэхүүний тоо, ачаа, тээшийн жагсаалт, жин зэргийг тусгана.

16. Бие бүрэлдэхүүн, тэдний агсамж, нормт хангалтын зүйлс, тээврийн хэрэгслийг авто тээвэрээр тээвэрлэх тохиолдолд тогтоосон маршрут, графикайн дагуу аяллыг зохион байгуулах бөгөөд замын дагуухь шаардлагатай хэсэг, уулзварт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг эрх бүхий алба зохион байгуулан хэрэгжүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шагнал олгох тухай

Хүнс, хөдөө аж ахуйн яамны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

аймгийн Арбулаг сумын 6 дугаар багийн малчин Дэндэвийн Чулуунбат нарт "Улсын сайн малчин";

1. Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багийн малчин Нямын Батдорж, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын 1 дүгээр багийн малчин Хурманбайн Арин, Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын 1 дүгээр багийн малчин Дамдинсүрэнгийн Дорж, Булган аймгийн Орхон сумын 3 дугаар багийн малчин Санжийн Пүрэв, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Цэцэгнуур багийн малчин Бэгзсүрэнгийн Авирмэд, Говь-Алтай аймгийн Цогт сумын Гэгээт багийн малчин Цэдэнбалын Гаанжуурсүрэн, Дундговь аймгийн Луус сумын 1 дүгээр багийн малчин Дамбийн Даржаа-Юу, Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Алтан багийн малчин Дамирангийн Цолмон, Сүхбаатар аймгийн Халзан сумын 2 дугаар багийн малчин Авирмэдийн Баатар, Сүхбаатар аймгийн Онгон сумын 1 дүгээр багийн малчин Ядамын Шархүүхэн, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 1 дүгээр багийн малчин Пужуугийн Олонбат, Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 2 дугаар багийн малчин Намхайн Цэвээндорж, Өвөрхангай аймгийн Тарагт сумын 3 дугаар багийн малчин Мөнхийн Шаарийбуу, Увс аймгийн Ховд сумын Шивэр багийн малчин Түвшингийн Дамба, Увс аймгийн Тариалан сумын Тарвагатай багийн малчин Нямаагийн Эрдэнэ, Ховд аймгийн Алтай сумын Алтангадас багийн малчин Бямбаагийн Дамдинбазар, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Шураг багийн малчин Цэрэннадмидын Насанжаргал, Хэнтий аймгийн Батноров сумын 3 дугаар багийн малчин Гүржавын Энхтайван, Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын 2 дугаар багийн малчин Гомбогарьдын Лааван, Хөвсгөл

2. Төв аймгийн Баянцогт сумын "Гуна" ХХК, Борнуур сумын "Борнуур" ХК, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Товхонхан" ХХК, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын "Хурх гол" ХХК, Говь-Алтай аймгийн Цогт сумын "Баянтооройн бүрд" ХК-д "Улсын тэргүүний тариаланч хамт олон";

3. Ховд аймгийн Буянт сумын иргэн Намсрайн Булгаа, Баян-Өлгий аймгийн Сарсай сумын иргэн Рыстаны Ерлан, Дархан-Уул аймгийн Орхон сумын иргэн Нацагдоржийн Сүхээ, Увс аймгийн Баруунтуруун сумын иргэн Төвөөгийн Дүнсээ, Улаангом сумын иргэн Түүвэйгийн Пүрэвдорж, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын иргэн Самдангийн Цоодол, Говь-Алтай аймгийн Халиун сумын иргэн Арьяабалын Дамдин-Ядам, Чандмань сумын иргэн Бадарчийн Додгон, Хэнтий аймгийн Мөрөн сумын иргэн Ламжавын Нямаа, Дорнод аймгийн Хэрлэн сумын иргэн Сундуйн Баттөмөр нарт "Улсын тэргүүний тариаланч" шагнал олгосугай.

4. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-д олгох тэмдэг, үнэмлэх, дурсгалын зүйлд зориулж 20.0 (хорин) сая төгрөгийг өөрийн төсвийн багцаас санхүүжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

НЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД

Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2004 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар хот

1. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

а/Бодлого, зохицуулалтын газар / стратегийн удирдлага, төлөвлөлт; сургалт, шинжилгээ судалгааны гэсэн 2 хэлтэстэй/;

б/Мэргэжлийн удирдлагын газар / шуурхай удирдлага, зохицуулалтын; мэдээлэл холбосны; урьдчилан сэргийлэх, хяналтын гэсэн 3 хэлтэстэй/;

в/Гамшгийн судалгааны төв /2 сектортой/;

г/Улсын нөөцийн газар /хэлтэсгүй/;

Хөтөлбөр, бүтэц, удирдлагын орон тооны тухай

д/Тамгын газар /төрийн захиргаа, хүний нөөцийн; хяналт- шинжилгээ, үнэлгээний; гадаад харилцаа, хамтын ажиллагааны гэсэн 3 хэлтэс, олон нийттэй харилцах албатай/;

е/Санхүү, бүртгэлийн хэлтэс.

3. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын удирдлагын орон тоог дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга тус бүр 1 байхаар тогтоосугай.

4. Газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг үндэслэн төсөвтөө багтаан агентлагийн орон тоог баталж мөрдүүлэх, харьяа салбар, нэгжийн бүтцийг боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Дашид үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

Ерөнхий сайдын 2004 оны 8 дугаар захирамжийн хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэнэ)-т гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, учирсан хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хууль тогтоомж, бодлогыг боловсронгуй болгох санал гаргах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн мэргэжлийн удирдлага, улсын нөөцийн зохицуулалтаар хангах, гал түймэртэй тэмцэх асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2. Үндэслэл

Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн

талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Иргэний хамгаалалтын газар, Улсын нөөцийн газар, Гал түймэртэй тэмцэх газар (хуучин нэрээр)-ын мөрдөж байсан үйл ажиллагааны стратеги, бүтцийн загварыг тус тус үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн хүрээ

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Гамшгаас хамгаалах тухай хууль;
- Галын аюулгүй байдлын тухай хууль;
- Ой, хээрийн түймрээс хамгаалах тухай хууль;

-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль;

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;

- Захиргааны хариуцлагын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;

-Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль;

-Бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлт, шинэчлэлийн удирдлага, үйл ажиллагааны төлөвлөлт болон байгууллагын өөрчлөлтийн арга зүйг хэрэглэсэн болно.

1.5. Удирдлагын ерөнхий чиг үүрэг, байгууллагын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Гамшгаас хамгаалах ерөнхий газар нь Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд гамшгаас хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, шийдвэр, үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлнэ. Засгийн газрын гамшгаас хамгаалах

зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий тохируулагч агентлаг-Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга нь Ерөнхий сайдын өмнө үүрэг, хариуцлага хүлээнэ. Гамшгаас хамгаалах ерөнхий газар нь Засгийн газрын бодлого төлөвлөлт, удирдлага зохицуулалт, яам, байгууллагын харилцан уялдаа холбоог хангах, зөв зохиистой шийдвэр гаргахад гамшгийн чиглэлээр зөвлөхийн үүрэг хүлээж санал санаачилга гаргаж ажиллана.

1.6. Үйл ажиллагааны стратеги, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана.

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын танхим, яам, агентлагийн удирдлага болон бүх шатны Засаг дарга, тэдгээрийн штаб, мэргэжлийн анги, албад, аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригч байна.

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, мэргэжлийн удирдлага, зохицуулалт нь үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдэх бөгөөд хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний гамшгаас хамгаалах зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн удирдлага, зөвлөлгөөгөөр яам, аймаг, нийслэлийг шуурхай хангах бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Гамшгаас хамгаалах ерөнхий газар нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй байна:

2.2.1. Зах зээлийн харилцаанд нийцүүлэн гамшгаас хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэх санал гаргах;

2.2.2. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг гамшгаас хамгаалах эрх ашигт нийцүүлэн төрөөс зохицуулах эрх зүй, зохион байгуулалтын орчинг боловсронгуй болгох;

2.2.3. Гамшгаас хамгаалах бүх шатны байгууллагыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх чадвар, чадавхийг нь нэмэгдүүлэх, гамшгаас хамгаалах штаб, аврах анги, отряд, салбар, улсын албаны бүрэлдэхүүн, иргэдийг сургаж бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулж чиглүүлэх.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын эрхэм зорилго нь гамшгаас хамгаалах замаар эмзэг байдал, эрсдэлийг бууруулах явдал мөн.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Гамшгаас хамгаалах ерөнхий газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1. Бодлого, зохицуулалтаар хангах;

2.4.2. Мэргэжлийн удирдлагаар хангах;

2.4.3. Гамшгийн судалгаа хийх;

2.4.4. Улсын нөөцийн удирдлага, зохицуулалтаар хангах;

2.4.5. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2.4.6. Санхүү, бүртгэл, хангалтын удирдлагаар хангах.

2.5 Үйл ажиллагааны гол зорилт

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1. Үйл ажиллагааны нэгдүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. Гамшгаас хамгаалах стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар

хангаж, гамшгаас хамгаалах эрх зүйг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.1.2. Гамшгаас хамгаалах бүх ангиллын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, сургалт зохион байгуулах.

2.5.2. Үйл ажиллагааны хоёрдугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг мэргэжлийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах;

2.5.2.2. Гамшгаас хамгаалах салбарын мэдээллийн сан, дотоод сүлжээг байгуулах, холбооны үйлчилгээгээр хангах;

2.5.2.3. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, хяналтыг зохион байгуулах.

2.5.3. Үйл ажиллагааны гуравдугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. Гамшгийн судалгаа, цацраг, химийн хоронд лабораторийн шинжилгээ болон багаж хэрэгслийн засвар, тохируулга хийх үйлчилгээ;

2.5.3.2. Гал түймрийн гаралтын байдалд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах.

2.5.4. Үйл ажиллагааны дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1. Улсын нөөцийн бодлого, зохицуулалтаар хангах;

2.5.4.2. Агуулахын аж ахуй, чанар, технологитой холбогдсон арга хэмжээг зохион байгуулах.

2.5.5. Үйл ажиллагааны стратегийн тавдугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;

2.5.5.2. Гамшгаас хамгаалах бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт шалгалт хийх;

2.5.5.3. Гадаад орон, олон улсын байгууллагатай гамшгаас хамгаалахад чиглэсэн

хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мэргэжлийн зөвлөлгөө, дэмжлэг, үйлчилгээгээр хангах;

2.5.5.4. Гамшгаас хамгаалах бодлогыг сурталчлах, хэрэглэгч буюу үйлчлүүлэгчийг мэдээллээр шуурхай хангах, олон нийттэй харилцах.

2.5.6. Үйл ажиллагааны зургадугаар зорилтын хүрээнд:


2.5.6.1. Гамшгаас хамгаалах байгууллагын төсөв, санхүүгийн бодлогын хэрэгжилтийг хангах;

2.5.6.2. Гамшгаас хамгаалах байгууллагын хангалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

2.6. Бүтээгдэхүүний анги, бүтээгдэхүүн
Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бүтээгдэхүүний анги, бүтээгдэхүүнийг тодорхойлж газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:



3. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйлжиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

3.1.1 Засгийн газрын үйл ажиллагааны стратегитэй уялдсан тус газрын стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус газрын үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2 Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3.1.3 Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, газрын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (аль болох цөөн шат дамжлагатай байх);

3.1.5. Тэнцвэрийг хангах хяналтын хүрээг тогтоох зарчим (тухайн газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар, удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх);

3.1.6. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхи бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн тус газрын үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

3.3. Зохион байгуулалтын бүтэц



Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж гарч байна.

3.1. Бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний зорилт, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын эрхлэх асуудлын хүрээний эрх зүйг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, гамшгаас хамгаалах бүх ангиллын сургалтыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, эмзэг байдал, эрсдэлийг бууруулах болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргаас Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын танхим, улмаар чиглэлийн яамдын стратеги төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр гаргах механизмд гамшгаас хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга байх бөгөөд шууд бус хэлбэрээр яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон иргэд байна. Энэ нэгжийн бүтцэд стратегийн удирдлага, төлөвлөлтийн, сургалт, судалгааны нэгж ажиллана.

3.3.2. Мэргэжлийн удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний зорилт, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын эрхлэх асуудлаар гамшгаас хамгаалах мэргэжлийн шуурхай удирдлагыг хэрэгжүүлэх, гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, мэргэжлийн удирдлагын үндсэн үүргийг хүлээж, гамшгаас хамгаалах бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг хангаж, гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, тэмцэх,

учирсан хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь яам, агентлаг, аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн анги, албыг мэргэжлийн болон арга зүйн удирдлага, үнэн зөв мэдээлэл, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь яам, агентлагийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга, гамшгаас хамгаалах бүх шатны байгууллага, штаб, мэргэжлийн анги, албад байна. Энэ нэгжийн бүтцэд шуурхай удирдлага зохицуулалтын, мэдээлэл холбооны, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хяналтын нэгжүүд ажиллана.

3.3.3. Гамшгийн судалгааны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний зорилт, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд гамшигтай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэх, цацраг, химийн хоронд лабораторийн шинжилгээ болон багаж хэрэгслийн засвар, тохируулга, үйлчилгээ хийх, гал түймрийн аюулын байдалд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үндсэн үүргийг хүлээж, гамшгийн судалгаа, шинжилгээтэй холбогдсон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн үйл ажиллагаа нь гамшгийн судалгаанд үндэслэн гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь гамшгийн байдал, үр дагаврыг ажиглах, шинжлэх замаар тус газрын бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, алба, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн мэдээлэл, судалгаа, дүгнэлт, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, бодлого, зохицуулалтын газрын дарга байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь яам, агентлаг, аймаг, нийслэл байна. Энэ нэгжийн бүтцэд гамшгийн

судалгаа шинжилгээний, галын шинжилгээний нэгж ажиллана.

3.3.4. Улсын нөөцийн удирдлага, зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгжийн зорилт, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын эрхлэх ажлын чиглэлээр улсын нөөцийн бодлого төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хандив, тусламжийн барааг хүлээн авах, холбогдох шийдвэрийн дагуу нөөцийг хуваарилах, нэр төрөл, тоо хэмжээгээр нөхөн бүрдүүлэх, нөөцийн бараа, материалын чанар, эрүүл ахуйн үзүүлэлтийн дүгнэлтийг мэргэжлийн алба, лабораториудтай хамтран гаргаж, энэ үндсэн дээр хадгалалтын хугацааг сунгах, сэлгэх, барааг удаан хадгалах шинэ технологийг нэвтрүүлэх, нөөцийн барааны агуулахын аж ахуй, технологи, бүртгэлийг боловсронгуй болгох үндсэн үүргийг хүлээж, нөөцийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн үйл ажиллагаа нь нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, сэлгэх, хадгалах, хамгаалах болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь удирдлагыг үнэн зөв мэдээлэл, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд байна.

3.3.5. Төрийн захиргаа, удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний зорилт, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн таавдугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, олон нийттэй харилцах үндсэн үүргийг хүлээж, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, урамшуулал, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг, мэргэшсэн төрийн тусгай албан хаагчийн хүчээр Гамшгаас хамгаалах ерөнхий

газрын төсралтгүй хэвийн жигд үйл ажиллагааг хангах, үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгоход чиглэнэ. Энэ нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын удирдлагад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадвархийг дээшлүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн албан хаагчид байна. Энэ нэгжийн бүтцэд төрийн захиргаа, хүний нөөцийн, хяналт-шинжилгээ, үнэлгээний, гадаад харилцаа, хамтын ажиллагааны, олон нийттэй харилцах нэгжүүд ажиллана.

3.3.6. Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний зорилт, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн зургадугаар зорилтын хүрээнд Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын эрхлэх асуудлыг хүрээний мөнгөн хөрөнгийн хөдөлгөөн, үлдэгдлийн тайлан, санхүүгийн тайлан тэнцэл, балансын шинжилгээ, дүгнэлтийг Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу гаргах, бүтээгдэхүүнд суурилсан төсөв зохиох, төсвийн зарцуулалтыг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, нягтлан бодох бүртгэлийн шинэ тогтолцоог нэвтрүүлэх, байгууллагын эд хөрөнгийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх, ахуй хангалтыг зохион байгуулах, үйлчлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь даргыг үнэн зөв мэдээлэл, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, Санхүү, эдийн засгийн яам байна. Энэ нэгжийн бүтцэд төсөв, санхүү, бүртгэлийн нэгж ажиллах бөгөөд хангалт, үйлчилгээний зарим хэсгийг гэрээгээр гүйцэтгүүлж болно.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ2004 оны 2 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН
ШИЙТГЭХ ХУУЛИЙН 58, 59 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН
ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ**

Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2002 оны) -ийн 8 дугаар бүлгийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт заасан "Сэжигтэн оргон зугтахыг завдсан..." , 59 дүгээр зүйлийн 59.5 дахь хэсэгт заасан "Хойшлуулашгүй тохиолдолд ..." гэсэн ойлголтыг шүүн таслах ажиллагаанд нэг мөр ойлгож, зөв хэрэглэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5 дахь хэсэгт заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт заасан "Сэжигтэн оргон зугтахыг завдсан..." гэдэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасан үндэслэлийн дагуу сэжигтнээр тооцогдсон этгээд Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас зайлсхийх зорилгоор зориуд санаатай байнгын оршин суугаа газраа орхих, нэрээ өөрчлөх, гадаад улсад болон өөр орон нутагт явахаар /гадаад улсын виз, зорчигчийн тасалбар авч/ бэлэн болсон, анх саатуулагдах үед өөрийн биеийн байцаалтад холбогдох мэдээллийг зориуд буруу ташаа танилцуулан зугтах, нуугдахыг оролдон идэвхтэй үйлдэл хийсэн зэрэг байдлыг ойлгож болохыг тайлбарласугай.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5 дахь хэсэгт заасан "Хойшлуулашгүй тохиолдолд..." гэдэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасан үндэслэлийн дагуу сэжигтнээр тооцогдсон этгээдийн бие, хувцас, орон байрнаас гэмт хэргийн эд мөрийн баримт, ул мөр илэрсэн буюу оргон зугтахыг завдсан, урьд нь оргож эрэн сурвалжлагдаж байсан, гэрч, хохирогчоос сэжигтэн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн болохыг шууд заасан, хаана оршин суудаг, хэн болох нь тодорхойгүй, бичиг баримт нь эргэлзээтэй, бусдын амь, бие эрүүл мэнд, эд хөрөнгөнд аюул учруулж болохуйц зүйлээр зэвсэглэсэн, бусдын амь бие, эд хөрөнгөнд хохирол учруулах талаар заналхийлэх нь биелэгдэх магадлалтай гэж үзсэн, сэжигтэн этгээд өөрийн үйл ажиллагааг удирдан жолоодох чадваргүй болтлоо мансуурсан, согтуурсан, урьд нь удаа дараа хорих ял шийтгүүлж байсан, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон зэрэг байдлыг хамааруулан ойлгож болохыг тайлбарласугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ч. ГАНБАТ**ШҮҮГЧ****Б.ДОРЖГОТОВ**Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.Улаанбаатар- 12
Төрийн ордон☎ 329612
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 3

☎ 329487